



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/МЕ

Есөнбулаг

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр 24 дүгээр хуралдааны 2022\_24 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн аймгийн газар зохион байгуулалтын 2024-2040 оны ерөнхий төлөвлөгөөний баримт бичгийг хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Д.Алтанзагас	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)
Гишүүдэд:	Д.Гаадамба	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн ерөнхий архитектор)
	Л.Хаш-Эрдэнэ	(аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын дарга)
	Ж.Мөнхболд	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Суурь судалгаа, газрын мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтэн)
	Г.Болд-Эрдэнэ	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн)
	А.Оюун-Эрдэнэ	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч)
	Ш.Батчимэг	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн)
	Г.Билэгсайхан	(Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл, хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн)
	Ц.Ханбүргэд	("Геоботаник"-ийн инженер) (гүйцэтгэгч)

2.

Нарийн бичгийн дарга: А.Пүрэвсэд (Газар зохион байгуулалт, төлөвлөлт, газар өмчлөлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)

2.Бодлогын баримт бичгийн ажлыг гэрээнд тусгагдсан ерөнхий болон тусгай нөхцөл, ажлын даалгавар зэрэг холбогдох баримт бичгийн бүрдэлтэй нийцүүлэн хүлээн авч, үр дүнг танилцуулахыг ажлын хэсэг (Д.Алтанзагас)-т үүрэг болгосугай.

3.Холбогдох акт, баримт бичгийг үндэслэн орон нутгийн өмчид бүртгэхийг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг), хадгалалт хамгаалалтад хяналт тавьж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны "Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө батлах тухай" 09 дүгээр тогтоолын хэрэгжилтийг ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т тус тус даалгасугай

ОРЛОГЧ



ГЧИНБАТ